



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/160

Дархан

Тамхи худалдан борлуулах энгийн  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, Засгийн газрын 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ын 5.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан 12 дугаар багийн 8 хороолол, Мангирт 1 дүгээр гудамжны 103/в байрны 107 тоотод үйл ажиллагаа явуулдаг “Тхоусанд Лайст” ХХК-ийн “Гэрэл маркет” хүнсний дэлгүүрийн тамхи худалдан борлуулах энгийн зөвшөөрлийг 3 жилээр олгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг энгийн зөвшөөрөл авсан “Тхоусанд Лайст” ХХК-ийн “Гэрэл маркет” хүнсний дэлгүүрийн захирал (О.Оюунгэрэл)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Шинэзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА Т.ТУЛГАА



4525010480

D.ajil.Zahiramj-2025